

MORE STEP – Mobility at risk: Sustaining the Mongolian Steppe Ecosystem

Newsletter No. 5

www.morestep.org

June 2023

Editorial

Welcome to our fifth newsletter! MORE STEP is a collaborative and interdisciplinary research project run by Mongolian and German partners and funded by the German Federal Ministry of Education and Research.

Scientists in interview

In this section, we would like to introduce MORE STEP scientists. Lukas Drees works as a researcher at the ISOE – Institute for Social-Ecological Research and the Senckenberg Biodiversity and Climate Research Centre (SBiK-F), Germany.

What are your research interests?

My main interest is the interplay between social and ecological dynamics. How do people shape the environment and how does the environment shape people's behaviour?

What do you find the most exciting about MORE STEP?

The intensity of exchange between this wide variety of disciplines, experiences and ideas with practitioners and scientists alike.

Which result has surprised you the most so far?


The enormous resilience of herders in particular and Mongolian pastoralism in general, which means that livelihood strategies have always been able to adapt to changing living conditions.



Introduction of our thematic group

'Integrated assessment'

The idea of an integrated assessment is to bring together ideas, knowledge and experiences from different perspectives. This is exactly what we did in a process of joint development of future scenarios. Scenarios are not to be mistaken with predictions about the future, but they are shared learning experiences by reflecting about different possibilities. We started with formulating the extrema of a best and a worst case and explored the possibility space between these boundaries afterwards. All of this helps to make more conscious and better directional decisions in the here and now.



Possibility space of future developments

The millennia-old tradition of Mongolian nomadic pastoralism was the focus of the joint work-shop, in which herders, non-governmental organisations, local and national government (agencies), further stakeholders as well as the MORE STEP project team, with scientific expertise from biology to economics and political science to remote sensing, participated.

It became clear that a coherent legislation between local and national levels, the decentralization of public services like schools and hospitals and social developments like urbanisation are important drivers of change. On the other hand, the condition of the grassland can serve as indicator of changes in the system.


Main challenges

The differences between the four scenarios formulated depend a lot on the political responses to the foreseeable challenges: Climate change, regulation of industrial activities, pasture management and its political regulation, educational reforms and digitalisation.

A nomadic pastoralism for the 21st century?

The nomadic pastoralism has always been highly adaptive to changing conditions and it has been more than once that its end has been predicted. The joint work with stakeholders and scientists has shown that Mongolian herders today again face a lot of challenges, but the Mongolian society and culture hold a lot of potential to respond to these challenges.

Learning together and discussing images of future pathways help to move as closely as possible towards positive futures in the identified possibility space.



Diversity of scenarios results from differences in living and environmental conditions

For questions related to this topic please contact Lukas Drees at drees@isoe.de or read our article at <https://doi.org/10.1080/13511610.2022.2100744>

Thank you very much! With best wishes,
MORE STEP Team

MORE STEP – Mobility at risk: Sustaining the Mongolian Steppe Ecosystem

Мэдээллийн товхимол №5

www.morestep.org

Зургадугаар сар, 2023

Редакцийн зурвас

Бидний бэлтгэсэн ээлжит мэдээллийн товхимолыг хүлээн авна уу!

MORE STEP нь Монгол, Герман хоёр орны хамтарсан, ХБНГУ-ын Засгийн Газрын Боловсрол, Судалгааны Яамны санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй салбар хоорондын судалгааны төсөл юм.

Судлаачийн ярилцлага

Энэ хэсэгт MORE STEP төслийн судлаачдаас танилцуулж байна.

Лукас Дрес – ХБНГУ-ын Нийгэм, экологийн судалгааны хүрээлэн (ISOE), Зенкенбергийн Биологийн төрөл зүйл ба Уур амьсгалын судалгааны төв (SBiK-F)-д тус тус судлаачаар ажилладаг.

Таны судалгааны чиглэл юу вэ?

Миний судалгааны гол чиглэл бол нийгэм, экологийн динамик хоорондын харилцан үйлчлэл юм. Тухайлбал, хүмүүс хүрээлэн буй орчноо хэрхэн бүрдүүлдэг, тэрхүү хүрээлэн буй орчин нь хүмүүсийн зан төлөвт эргээд хэрхэн нөлөөлдөг талаар сонирхон судалдаг.

Таны бодлоор MORE STEP төслийн хамгийн онцлуштай тал юу вэ?

Дадлагажигч, эрдэмтэд ялгаагүй хоорондоо өөр өөрийн салбар, туршлага, санал санаачилгыг харилцан солилцдог байдал.

Одоогоор олон хамгийн их гайхшруулсан үр дүн гэвэл?

Ерөнхийдөө Монголын бэлчээрийн мал аж ахуй, түүн дотроо малчдын асар их тэсвэр тэвчээр. Малчдын амьдрах арга барил нь амьдралын аливаа нөхцөл байдлын өөрчлөлтөд ямагт дасан зохицож ирсэн байдаг.

Манай сэдэвчилсэн бүлгийн танилцуулга “Нэгдсэн үнэлгээ”


Тулгарч буй асуудлууд

Урьдчилан таамаглаж болох сорилтуудад төрийн зүгээс авах хариу арга хэмжээнээс ихээхэн хамаарч, бидний боловсруулсан дөрвөн хувилбар өөр хоорондоо ялгагдана. Үүнд: Уур амьсгалын өөрчлөлт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зохицуулалт, бэлчээрийн менежмент ба төрийн зохицуулалт, боловсролын шинэчлэл болон дижиталчлал.

21-р зууны нүүдлийн мал аж ахуй?

Нүүдлийн мал аж ахуй цаг ямагт нийгэм, орчны өөрчлөлтөд дасан зохицох чадвартай байсаар ирсэн ч төгсгөлийг нь урьд өмнө нэг бус удаа урьдчилан таамаглаж байжээ. Өнөө цагийн малчид олон тооны сорилттой тулгарсаар байгаа боловч Монголын нийгэм, соёлд эдгээр сорилтыг даван туулах асар их нөөц бололцоо байгааг оролцогч талууд, эрдэмтэдтэй хамтран хийсэн ажил харууллаа.


Хамтдаа суралцаж, ирээдүйн чиглэл, замуудыг зураглан хэлэлцэх нь бидний тодорхойлсон боломжит орон зай дахь зэрэг ирээдүй рүү аль болох ойртоход туслах юм.



Ирээдүйн хөгжүүлэлтийн боломжит орон зай

Малчид, төрийн бус байгууллагууд, орон нутгийн удирдах газар, засгийн газар (агентлагууд), мөн түүнчлэн биологиос эдийн засаг, улс төр судлалаас зайгаас тандан судлал хүртэлх шинжлэх ухааны туршлагатай MORE STEP төслийн баг болон бусад оролцогч талуудын оролцсон хамтарсан зөвлөгөөний үндсэн сэдэв нь Монголын нүүдлийн мал аж ахуйн олон мянган жилийн уламжлал байв.

Энэ үеэр орон нутаг, үндэсний хэмжээний уялдаа холбоо бүхий хууль тогтоомж; хотжилт гэх мэт нийгмийн хөгжил; сургууль, эмнэлэг зэрэг олон нийтийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах тал дээр төвлөрөх нь өөрчлөлт хийх гол хөдөлгөгч хүч болох нь тодорхой болсон. Нөгөөтэйгүүр, бэлчээрийн төлөв байдал нь уг системийн өөрчлөлтийн нэг итгэлцүүр болох юм.



Хувилбаруудын олон янз байдал нь хүрээлэн буй орчны болон амьдрах нөхцөлийн ялгаатай байдлаас үүдэлтэй

Энэхүү сэдэвтэй холбоотой асуудлаар судлаач Лукас Дрестэй drees@isoe.de хаягаар холбогдоорой. Дэлгэрэнгүй судалгааг дараах холбоосоор орж уншина уу:

(<https://doi.org/10.1080/13511610.2022.2100744>)

Хүндэтгэсэн, MORE STEP төслийн баг

